

“ГОЛЛАНД ӨВЧИН БА МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛАГИЙН АШИГЛАЛТ: СУРГАМЖ, ШИЙДЭЛ”

А.Даваасүрэн¹

Хураангуй: Байгалийн баялагийн улмаас дэлхийн зарим улсууд “голланд өвчин”-д нэрвэгдэж байсан талаарх эрдэмтэдийн судалгаа, голланд өвчний илэрэх шинж тэмдэг, түүний үргэлжлэх үе шат, Монгол Улс “голланд өвчин туссан эсэхийг гэрчлэх макроэдийн засгийн шинжилгээ, үнэлэлт, дүгнэлт, Монгол Улсын төр, засгийн удирдлагын зүгээс ард иргэдэд “Хүний хөгжлийн сан”-гаас бэлэн мөнгө тараасны үр дүнд тус улсын эдийн засгийг “голланд өвчин” тусахад нөлөөлсөн байдал, голланд өвчнөөс урьдчилан сэргийлж чадсан зарим улсуудын туршилага, халуун мөнгөний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээнүүд, голланд өвчний улмаас Олон Улсын Валютын сангийн “Стенд бай” хөтөлбөрт Монгол Улс хамрагдах болсон нөхцөл байдал, байгалийн баялагийн нөөцийг үр ашигтай ашиглахын тулд үндэсний инновацийн тогтолцоог бий болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага, шинээр аж үйлдвэржсэн орнуудын үндэсний инновацийн тогтолцооны загварыг Монгол Улсад нутагшуулах боломж, уг тогтолцооны суурь үндэс болсон аж үйлдвэр, хөдөө аж ахуйн кластеруудыг орон нутагт байгуулах шаардлагатай гэж судлаач үзэж байна.

Түлхүүр үгс: Байгалийн баялаг, голланд өвчин, макроэдийн засгийн үзүүлэлт, “Хүний хөгжлийн сан”, Олон Улсын Валютын сан, “Стенд бай” хөтөлбөр, Монгол Улс, үндэсний инновацийн тогтолцоо, хөдөө аж ахуйн кластер гэх мэт.

The abstract: Research report scientist of the world about natural resource has suffering economic development of some countries, that names “Dutch disease”, the

¹ ШУА-ийн ОУХХ-ийн ЭШТА, Доктор (Sc.D), Профессор

*“Голланд өвчин ба Монгол улсын эрдэс баялагийн ашиглалт:
Сургамж, шийдэл”*

symptoms of appearance of “Dutch Disease”, its continue stage, evaluation and assessment of macroeconomic condition, which witness “Dutch disease in Mongolia, as results of a distribution of cash the people from “Human development fund” by Mongolian government, what strikes negative affected on the economy of the Mongolia, experience of some countries about the measures, reducing the negative impact, what could prevent Dutch disease from hot money, conditions for including Mongolia to “Standby agreement” of the International Monetary Fund, essential necessity of create the national innovation system to effective use of natural resources, the design for adaptation of experiences development of national innovation system of newly industrialized countries, which is considered that it is necessary to establish an industry and agriculture clusters in Mongolian.

Key words: *Mongolia, natural resources, dutch disease, macroeconomic indicators, human development fund, International Monetary Fund, Standby agreement, national innovation system, agricultural cluster.*

Байгалийн нөөц гэж газар тариалан, мал аж ахуй эрхлэх боломжтой газар, бэлчээр, ой мод, хөрсөн доорх нөөц буюу үнэт металл, эрдэс баялаг, нүүрс, газрын тос, байгалийн хий, төмрийн хүдэр зэргийг ойлгож байна. Өөрөөр хэлбэл байгалийн баялаг нь хүний үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй, нөхөн сэргээгдэшгүй нөөц юм.

Байгалийн баялаг ихтэй улс орнууд хөгжлөөр хоцрогдоод байгаа шалтгааныг өнгөрсөн зууны дунд үеэс дэлхийн эрдэмтэд судалсан байдаг. Тухайлбал, 1959 онд Голланд улсын хойд тэнгист нефть, байгалийн хийн нөөц ихээр илэрч, тэдгээрийг экспортод гаргах болсоноор, тус улсын үндэсний валют гульдений ханш өсөж, гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн хэмжээ нэмэгдэж, төсвийн орлого, зарлага нэмэгдэж, засгийн газрын зардал эрс өсөж, богино хугацаанд эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд сайжирсан боловч газрын тосны салбарын эрчимтэй хөгжлөөс болж эдийн засгийн бусад салбаруудаас ажиллах хүчин, санхүүгийн нөөцүүд уул уурхай руу шилжих болсоноор боловсруулах салбарыг дампуурахад хүргэсэн энэхүү үзэгдэлийн талаар анх 1977 онд “эдийн засагч” сэтгүүлд хэвлэгдэж энэ үзэгдэлийг Голланд өвчин (Dutch disease) гэж нэрлэх болсон.

Голланд өвчний анхны шинж тэмдэг Испаний иргэн Колумба Америк тивийг анх нээж, Америкаас их хэмжээний алт оруулж ирснээр

Испани улс гэнэт баяжиж алтаа Европын бусад орнуудад борлуулж, оронд нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн импортоор авах болсон. Эцэст нь Испани улсын аж үйлдвэрийн хөгжил зогсож, үндэсний боловсруулах үйлдвэрүүд бүрэн дампуурдаг².

1969 онд дэлхийн зах зээл дээр 1 баррель газрын тосны үнэ 1,27 ам.доллар байхад Их Британи газрын тосны импортлогч байсан. Тэгвэл 1974 онд 10,97 долларт хүрч өсөхөд Их Британи улс Шотландын Хойд тэнгис дэхь газрын тосны өрөмдлөгийн ажлыг эрчимтэй хийж эхэлсэн бөгөөд 1979 онд 1 баррель 30,96 долларт хүрэхэд Их Британи улс газрын тосны экспортлогч болж хувирсан. Энэ үед фунтстерлингийн үнэ өсөж, экспорт өрсөлдөх чадваргүй болж, ажилчид цалин хөлсөө нэмэгдүүлэхийг шаардаж улмаар нийгмийн бухимдал үүсгэсэн. Ийм үзэгдэл манай хойд хөрш ОХУ-д 2008-2009 онд гарч байлаа.

Байгалийн баялагийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар Жефрей Сакс (Jeffrey D. Sachs), Эндрю Мэллинжер (Andrew M. Warner) нар “Байгалийн баялаг ба эдийн засгийн өсөлт³” гэсэн судалгааны ажилдаа тодорхой бичсэн байдаг. Дараа нь Жоан Мюиски ба Тим Руттен нар “Газар зүй ба эдийн засгийн өсөлт⁴” өгүүлэлдээ “газар зүйн байршилт, хүн амын тоо нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар бичсэн. Мөн Нобелийн шагналт Джозеф Стиглиц (Joseph Stiglitz) “Байгалийн баялгийн хараал гай дахин ирэв үү⁵” гэсэн номондоо “Голланд өвчний” тухай тодорхой бичсэн байдаг.

Дээрх эрдэмтэд өөрсдийн судалгааны үр дүнгээр байгалийн арвин их нөөц баялагтай улсаас, ямар ч баялаггүй улс хүнээ хөгжүүлэх замаар урт хугацаанд эдийн засгийн өсөлтөөрөө гүйцэж түрүүлж болдог. Байгалийн баялагийн экспортын өндөр орлого нь үндэсний валютын ханшийг өсгөж, улмаар хямдарсан импортоор гадаадаас тансаг хэрэглээний барааг импортоор оруулах болдог. Ийм байдал нь тухайн улсын үйлдвэрлэгчид ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид

2 Ebrahim-zadeh, Christine (March 2003). "Back to Basics – Dutch Disease: Too much wealth managed unwisely". Finance and Development, A quarterly magazine of the IMF. IMF. Archived from the original on 2008-06-17. Retrieved 2008-06-17. "This syndrome has come to be known as "Dutch disease".

3 Jeffrey D. Sachs, Andrew M. Warner "Natural resource abundance and economic growth", Working paper 5398, National bureau of economic research Cambridge December 1995


4 Geography and Economic Growth. John Luke Gallup, Jeffrey Sachs, Andrew M. Warner /April 1998/. John Luke Gallup, Jeffrey Sachs, Andrew M. Warner /April 1998/

5 We Can Now Cure Dutch Disease, By Joseph Stiglitz, Guardian. August 18, 2004

“Голланд өвчин ба Монгол улсын эрдэс баялагийн ашиглалт:
Сургамж, шийдэл”

импортын үерт автаж, импортоор орж ирсэн хямд бөгөөд чамин бараагай өрсөлдөх чадваргүй болдог. Ингэснээр олон үйлдвэрлэгчид дампуурч, ажилгүйчүүдийн эгнээнд шилждэг. Ингэж улс орны эдийн засаг тэнцвэрээ алдаж хямралд ордог. Яваандаа түүхий эд шавхагдаж, дэлхийн зах зээл дээр үнэ унах үед тус улсын эдийн засаг хямарч төлбөрийн болон төсвийн ихээхэн алдагдалд орж, тус улс гадаадын зээл тусламжийн хараат байдалд бүрэн ордог. Энэ үед тус улсын төр засгийн удирдлагын экспортын их хэмжээний орлого, гадаадын их хэмжээний зээл тусламжийн зарцуулалтад бялуурч ёс суртахууны доройтолд орж, хүнд суртал авилгын уурхай болж хувирдаг.

Ингэж байгалийн баялагаар арвин бөгөөд буурай хөгжилтэй ядуу улсууд “Голланд өвчин” ихэвчлэн нэрвэгдэх өндөр эрсдэлтэй гэж судлаачид үздэг. Эдгээр орнуудыг “байгалийн баялагийн гай” буюу эсвэл “байгалийн баялагийн хараал хүртсэн” гэж нэрлэдэг. Дэлхийн улс орнуудын хөгжсөн туршлагаас харахад байгалийн баялагаа ашиглахын зэрэгцээ хүнээ хөгжүүлж засаглалын зөв менежментийг хэрэгжүүлдэг улс орон илүү чинээлэг болдог бол баялагаа зөвхөн экспортолж, түүнээс олсон орлогоо үр ашиггүй зарцуулдаг улсууд улам ядуурч төр засаг нь ард иргэдийнхээ аж амьдралын түвшинг доривтой дээшлүүлж чадахгүй харин ч ядуурал, ажилгүйдэл нь улам нэмэгдэж, хүнд сурталжиж, цөөхөн хүмүүс баяжиж ард иргэд нийтээрээ ядууралд нэрвэгдэж орлогын тэгш бус хуваарилалт ихэсдэг. Эдгээр улсууд байгалийн баялагийн үнэ, ханш дэлхийн зах зээл дээр өсөхөд тансаглаж, буурахад ядуурч гуйлагчлах хандлагатай байдаг. Зураг 1-ээс харна уу.



Голланд өвчний үед илрэх шинж тэмдэгүүд:

I үе шатанд: 1-2 жилийн хугацаанд үргэлжлэх ба дараах эерэг үзэгдэлүүд ажиглагдана. Үүнд:

- Төлөвлөөгүй их хэмжээний экспортын орлого орж ирнэ (төсвийн орлого, зарлага огцом өсөж, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж нэмэгдэнэ).
- Төгрөгийн ханш огцом чангарч импортын үер болно.
- Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл их хэмжээний ашигтай гарч болон макроэдийн засгийн үзүүлэлтүүд сайжирна.

Сөрөг үзэгдэлүүд:

- Эдийн засгийн бусад салбаруудаас нөөцүүд (ажиллах хүч, санхүү, технологи) шилжилт хөдөлгөөн явагдана.
- Төгрөгийн ханш огцом чангарснаас болж экспорт өрсөлдөх чадваргүй болно.
- Эдийн засгийн бүтэц муудаж, боловсруулах салбар уналтанд орно.
- Гадаад валютын нөөц шавхагдана.

II үе шат 1-2 жилийн хугацаанд үргэлжлэх ба дараах сөрөг үзэгдлүүд ажиглагдана. Үүнд:

- Барааны үнэ хязгааргүй өснө.
- Ажилчид цалингаа нэмэхийг шаардаж улмаар нийгмийн бухимдал газар авна.
- Төрийн албанд хүнд суртал, авилга газар авна.
- Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж зогсоно

III үе шат 1- 2 жилийн хугацаанд үргэлжлэх ба дараах сөрөг үзэгдлүүд ажиглагдана. Үүнд:

- Үйлдвэрлэгч эдийн засгаас хэрэглээний эдийн засаг руу шилжинэ.
- Улс орон өрийн дарамтад орж зээлжих зэрэглэл буурна.
- Нийгмийн ёс суртахуун, үнэлэмж доройтно.
- Маш цөөхөн хүн хагартлаа баяжиж, дарангуйлалын засаглал тогтоно.
- Засаглалын чанар муудна.

*“Голланд өвчин ба Монгол улсын эрдэс баялагийн ашиглалт:
Сургамж, шийдэл”*

IV үе шат дээр төрийн зүгээс шийдвэрлэх арга хэмжээ авахгүй бол хямрал үргэлжлэх аюултай бөгөөд V шатанд иргэний дайн гарч, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд ноцтой аюул учруулахад хүргэдэг гэж эрдэмтэд үзэж байна.

Голланд өвчин Монгол Улсад туссан уу?

Хүснэгт 1. Монгол Улсын макроэдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Он	ДНБ-ний өсөлт %	1 хүнд ногдох ДНБ \$	Гадаад валютын дундаж ханш	Гадаад валютын нөөц сая \$	Гадаад өрийн хэмжээ тэрбум \$	Мөнгөний нийлүүлэлт өсөлт %	Зээлийн үлдэгдэлийн өсөлт %
2010	6,4	3050	1355,9	2091,2	---	55,6	23,0
2011	17,3	3701	1265,5	2273,9	---	59,2	72,8
2012	12,3	4282	1359,4	3629,2	13,1	45,6	23,9
2013	11,6	4312	1525,7	2248,0	18,2	49,3	54,0
2014	7,8	4138	1818,3	1649,9	20,9	47,9	16,1
2015	2,4	3936	1970,7	1707,2	21,8	43,4	-6,5
2016*	1,3	--	2520,1	1116,9	24,2	20,6	1,2

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл, Монгол банкны статистикийн мэдээлэл, Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, 2012-2016 он.

Хүснэгт 1-ээс харахад дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ өссөний улмаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011-2012 онд дэлхийд байхгүй 17,5 хувьд хүрч макроэдийн засгийн үзүүлэлтүүд бүгд зэрэг өсөж, ард иргэд тансаглаж байсан бол 2014 оноос эдийн засгийн нөхцөл байдал бүхэлдээ огцом муудаж, гадаад валютын ханш болон гадаад өрийн хэмжээ огцом нэмэгдэж, валютын нөөц шавхагдаж, 1 хүнд ногдох орлогын хэмжээ эрс буурч, ажилгүйдэл, ядуурлын хэмжээ нэмэгдэж нийгэмд бухимдал газар авч эхлэж байна.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засгийн бүтэц
(хувиар)

Он	ХАА салбар	Уул уурхай, олборлох салбар	Боловсруулах салбар	Цахилгаан, дулаан, эрчим хүчний салбар	Худалдааны салбар	Үйлчилгээний салбар
2010	14,3	22,7	6,4	2,6	8,3	21,3
2011	12,3	21,0	6,0	2,3	17,3	6,9
2012	11,2	17,8	9,0	1,8	19,9	28,7
2013	13,4	15,9	10,7	1,9	18,4	22,1
2014	13,3	17,0	10,6	2,0	16,9	27,8
2015	13,6	17,0	9,7	2,3	17,0	28,4

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл, Монгол банкны статисткийн мэдээлэл, Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, 2012-2016 он.

Дээрх 2 хүснэгтээс харахад манай улсын эдийн засгийн бүтэц муудаж, эдийн засагт худалдаа, үйлчилгээний эзлэх хувийн жин нэмэгдсэн байна. Ингэснээр улс орон өрийн дарамтад орж, нийгэмд ажилгүйдэл, ядуурал хавтгайрч, засаглалын чанар муудаж, төрийн үйл ажиллагаанд иргэдийн зүгээс итгэх итгэл унаж, төрийн үйл ажиллагаанд хүнд суртал бий болж, төрийн албаны бүх шатанд авилга хээл хахууль газар авсан байгаа нь Монгол Улс Голланд өвчин бүрэн туссан байна гэж баттай үзэж болохоор байна.

Дэлхийн зах зээл дээр алт, зэс болон бусад байгалийн баялгийн үнийн өсөлтөөс орж ирсэн орлогыг манай улсын төр, засгийн удирдлага өөрсдөө их тансаглаж, гарынхаа салаагаар урсгаж, маш үрэлгэн зарцуулж “Эх орны хишиг”, “Шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж”, “Хүүхдийн мөнгө”, “Ахмадын хишиг”, “Одонгийн мөнгө”, “Шинэ гэр бүлд олгох тэтгэмж” гэх мэт нийгмийн шинж чанартай популист арга хэмжээнүүдийг санхүүжүүлж иргэдэд бэлэн мөнгө тараах ажлыг хийснээр монголын эдийн засгийг Голланд өвчнөөр өвчлүүлсэн гэж

*“Толланд өвчин ба Монгол улсын эрдэс баялагийн ашиглалт:
Сургамж, шийдэл”*

дүгнэж байна. Тухайлбал, 2009-2013 онд “Хүний хөгжлийн сан”-д ашигт малтмалын нөөц ашигласаны болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр хэлбэрээр 1306,0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, дээрх зорилгоор 2228,8 тэрбум төгрөгийн зарлага гаргаж үлдэх 922,8 тэрбум төгрөгийн хөрөнгийн дутагдалыг “Оюу Толгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” ХХК-аас урьдчилан авсан хүүтэй төлбөр, Засгийн газрын бондоор санхүүжүүлсэн байна⁶. Хүний хөгжил сангаас бэлэн хэлбэрээр зарцуулсан энэхүү 2,2 их наяд төгрөгийг манай улсын эдийн засгийн боловсруулах салбарыг хөгжилд, дэд бүтцийн бүтээн байгуулалтад зарцуулсан бол дараах боломжууд байлаа.

Хүснэгт 3. Хүний хөгжил сангаас бэлнээр тараасан мөнгөөр барих байсан бүтээн байгуулалтын хэмжээ

Тараасан мөнгөний хэмжээ	Эс хайлуулах үйлдвэр барих (500-800 ажилчинтай)	Боловсруулах үйлдвэр барих (180-200 ажилчинтай)	Автозам барих (4 этгээ бүхий)	Төмөр зам барих (1524 мм царигийн)
2228,8 тэрбум төгрөг	1 ширхэг	5 ширхэг	4625,5 км	437,7-490,3 км
Бүтээн байгуулалт хийх байсан боломжууд	800 ажлын байр шинээр бий болгох	1000 ажлын байр шинээр бий болгох	Одоо ашиглаж байгаа асфальт хучилттай 2434 км автозамын уртаас 2 дахин илүү шинэ зам барих	Төмөр замын сүлжээний урт 1815 км, тэнд 15560 ажилчид ажиллаж байна. Хэрэв энэ хөрөнгөөр шинэ төмөр зам барьсан бол төмөр замын уртыг 490,3 км уртасгаж тэнд 4203 шинээр ажлын байр бий болгох байлаа.

⁶ Монгол Улсын Үндэсний Аудитын газраас “Хүний хөгжил сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн” хийсэн аудитын тайлан. Улаанбаатар, 2014. <http://www.audit.gov.mn/files/report/compliance/hugjil-san.pdf>

Тайлбар:

1. 180-200 ажилчидтай боловсруулах үйлдвэр барихад дундажаар 230-250 сая доллар, 500-800 ажилчинтай зэс зайлуулах болон төмөрлөгийн үйлдвэр барихад 800-1200 сая доллар шаардлагатай гэж тооцсон байдаг.
2. “Монголын Төмөр Зам” ТӨХК-иас “Таван Толгой-Чойбалсан” чиглэлийн 1 км төмөр зам барихад 2,5-2,8 сая доллар гэж тооцсон байдаг.
3. “Чингис деволонмент ланд” группээс 2013 онд гаргасан судалгаагаар Монгол Улсад 4 эгнээтэй 1 км автозам барихад 515-530 сая төгрөг шаардлагатай гэж тооцсон байдаг.

Хүснэгт 4. Монгол Улсын гадаад худалдааны бүтэц
(хувиар)

Үзүүлэлтүүд	Эрдэс баялагийн түүхий эд		Эцсийн бөгөөд бэлэн бүтээгдэхүүн	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
2010	81,0	23,6	8,5	73,8
2011	89,2	19,3	6,1	78,9
2012	98,2	23,5	6,0	72,4
2013	81,9	27,4	7,4	51,5
2014	83,0	28,0	6,5	53,8
2015	78,8	24,7	7,3	58,1

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл, 2012-2016 он.

Хүснэгт 4-өөс харахад манай улсын эдийн засгийн бүтэц тун муу, экспорт нь түүхий эд давамгайлсан бүтэцтэй, байгалийн баялагаа олборлоод ямар боловсруулалт хийхгүй түүхийгээр нь шууд экспортод гаргаж, оронд нь өргөн хэрэглээний бэлэн бараа, бүтээгдэхүүн импортоор авч хэрэглээгээ хангадаг, гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай, өндөр технологийн бараа, бүтээгдхүүний үйлдвэрлэл байхгүйтэй адил байна. Энэ нь аж үйлдвэрийн суурь бүтэц хөгжөөгүй, хүмүүсийн бүтээлч сэтгэлгээ хомс, харин бэлэнчлэх сэтгэлгээ давамгайлсан, шинжлэх ухааны судалгаа, хөгжилд зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ хангалтгүй, зарцуулж байгаа жаахан хөрөнгийн үр ашиг муутай, засаглалын чанар муу, төрийн албаны чадамж сул, төрийн

*“Голланд өвчин ба Монгол улсын эрдэс баялагийн ашиглалт:
Сургамж, шийдэл”*

бодлого алсын хараагүй, судалгаа, шинжилгээн дээр суурилсан төрийн эдийн засгийн удирдлага, зохион байгуулалт, хүний хөгжил, аж үйлдвэрийг хөгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны бодлого, төлөвлөлт байхгүй, өнөө маргаашийг аргацаасан гал унтраасан байдалтай холбон тайлбарлаж болохоор байна.

2010-2011 оны үед манай улстай адил байгалийн баялагийн хамааралтай эдийн засагтай Чили, Австраль, Канад, Шинэ Зеланд зэрэг орнууд үнийн өсөлтийн орлогыг юуны өмнөх үний хөгжилд (боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд), боловсруулах аж үйлдвэрийн салбартаа бүтээн байгуулалт хийх, эдийн засагтаа диверсификаци хийхэд зарцуулж эдийн засгийн ерөнхий тэнцвэрийг хангахад зарцуулж халуун мөнгийг хөргөж, эдийн засгаа Голланд өвчнөөс сэргийлж чадсан туршлага байна.

Эдгээр орнууд Голланд өвчнөөс урьдчилан сэргийлж, халуун мөнгөний сөрөг нөлөөллийг багасгахын тулд дараах аргуудыг хэрэглэсэн байна. Үүнд:

- Байгалийн баялагийн экспортоос орох орлогыг удаашруулах. Гадаадад тусгай санд байршуулж бага багаар оруулж ирэх; Хөгжиж буй орнуудын хувьд ажилгүйдэл, ядуурлын эсрэг тэмцэлд хөрөнгө хэрэгтэй байдаг учир энэ нь хэцүү байдаг.
- Үндэсний валютын ханшийн өсөлтийг удаашруулахын тулд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэх, улсын төсвийн зардлыг танах;
- Өсөлтөөс орж ирсэн орлогыг хэмнэх, улс орныхоо ирээдүй хойч үедээ зарим орлогоо авч үлдэх; Жишээ нь Австралийн ирээдүйн засгийн газрын сан, Норвегийн хөгжлийн сан, ОХУ-ын тогтворжуулалтын сан, Азербайжан Улсын Газрын тосны сан гэх мэт.
- Татвар ногдуулах, тоон хязгаар тогтоох замаар хөрөнгийн дотогшлох томоохон урсгалыг хязгаарлах;
- Иргэд, компаниудын хуримтлалыг нэмэгдүүлэхэд татвар, хураамжаас чөлөөлөх замаар дэмжих;
- Эрүүлийг хамгаалах, боловсрол, шинжлэх ухаан салбарын хөгжлийг дэмжих, хүний хөгжилд зориулах;

- Дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Өвчинд өртсөн, хөгжлөөр хоцорч буй аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулахад татаасыг нэмэгдүүлэх замаар дэмжих гэх мэт.

Тэгвэл Монгол, Мексик, Нигер, Венесуэль зэрэг улсууд “Голланд өвчин” тусаж эдийн засгаа удирдаж чадахгүй, өрийн дарамтад орж ОУВС-ын “Extended Fund Facility” буюу “Стенд бай” хөтөлбөрт хамрагдахаар болж хөгжлөөрөө улам бүр хоцорсоор байна.

“Стенд бай” хөтөлбөрт 2009 оны өмнө дэлхийн эдийн засгийн хямрлаас гарахын тулд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн байсан Украин, Беларусь, Армян, Молдова, Киргиз зэрэг орнууд хамрагдсан боловч эдгээр улсуудын эдийн засгийн өсөлт -5-15% буурч, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж чадаагүйгээр барахгүй харин өрийн хэмжээ нэмэгдэж тухайн улсын үндэсний валютын ханш хөтөлбөр хэрэгжүүлэхийн өмнөх үеэс хурдацтай унасан гэсэн гашуун сургамж байна.

Зарах юу ч үгүй, үгээгүй хоосон ОУВС-ын “Стенд бай” хөтөлбөрийн үйлчилгээ байнга авдаг дэлхийн хамгийн ядуу буурай Африкийн Того, Мадагаскар, Малави, Нигер, Зимбабве, Бурунди зэрэг орнуудтай харьцуулахад өргөн удам нутагтай, газар дээрээ 70 гаруй сая малтай, газрын хөрсөн доор арвин их баялагтай, харьцангуй боловсролтой, залуу хүн амтай, шинжлэх ухаан, технологи тодорхой түвшинд хөгжсөн, дэлхийн 2 том зах зээлийн дунд байдаг зэрэг Монгол Улс ийм ядуу бөгөөд дэлхийн туйлын ядуу орны түвшинд амьдарч байгаад гадаад, дотоодын судлаачид гайхаад барахгүй байна.


Дүгнэж хэлэхэд байгалийн нөөц нь нөхөн сэргээгдэхгүй учир байгалийн баялагийн нөөцийг үр ашигтай үе шаттай ашиглах, баялагаас орж ирж байгаа орлогыг тэгш тэнцүү хуваарилах, эдийн засгийнхаа бусад салбарыг (ялангуяа боловсруулах салбар, хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан) хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болгон хувиргах, байгалийн нөхөн сэргээлтийг цаг тухайд нь хийж байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах нь туйлын чухал байна. Байгалийн баялагт тулгуурласан, хэрэглээ нь (засгийн газар, хувийн сектор) хуримтлалаас даваж, байгаль экологийн тэнцвэрт

байдал алдагдаж, ус, хөрс, ургамал, агаарын бохирдол ихсэж, цөлжилт ихсэж, нийгэмд орлогын тэгш бус хуваарилалт, ажилгүйдэл, ядуурал газар авч, гадаад зах зээлээс их хамааралтай хөгжлийн одоогийн загвараар цаашид явах боломжгүй болох нь харагдаж байна.

Иймээс байгалийн нөөц баялгаа зохистойгоор ашиглаж, экологийн тэнцвэрт байдлыг хангах, хадгалах замаар монгол хүний амьдралын нөхцлийг сайржуулах чиглэгдсэн тогтвортой хөгжлийн загвараар хөгжих шаардлага гарч байна. Энэхүү тогтвортой хөгжлийн загвар нь хүний хөгжлийн өндөр үзүүлэлт болон шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжил дээр тулгуурлан байгалийн баялагийг өөрсдийн хэрэгцээнд тааруулж ашиглаж, байгальд хор хөнөөл багатай техник, технологи ашиглаж урт хугацаанд хөгжлийн өндөр түвшинд хүрэх, хэрэглээний эдийн засгаас үйлдвэрлэгч эдийн засаг руу шилжихэд туслахад чиглэгдэх ёстой юм. Эдгээр зорилтыг амжилттай хэрэгжүүлэх нь эдийн засгийн хөгжлийн шинэ загвараа хэрхэн зөв оновчтой тодорхойлохоос шалтгаална гэж үзэж байна. Чадахгүй бол Монгол Улс удахгүй Африкийн зарим буурай хөгжилтэй орнуудын гашуун туршлагыг давтахад хүрэх эрсдэлтэй байна.

Өндөр хөгжсөн орнуудын туршлага, практикаас харахад төрөөс шинжлэх ухаан, боловсрол, дэд бүтэц илүү ач холбогдол өгч, тэдгээрийг хөгжүүлэхэд бүх талаар дэмжиж улс орны үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн байдаг. Үүний тулд нэгдүгээрт, өөрсдөө мэдлэгийг бий болгоход, судалгаа туршилтад их хөрөнгө зарцуулахын оронд гадаад орнуудын шинэ мэдлэг, шилдэг технологи, ур чадварыг нутагшуулах, инновацийн бүтээгэдэхүүн дамжуулах, тэдгээрийг үндэсний үйлдвэрлэлд нэвтрүүлэх ашиглахад компаниуд, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвүүдийн оролцоо чухал бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад төр, засан хамгийн том шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх ёстой болно. Хоёрдугаарт, төр, засгаас үндэсний инновацийн тогтолцоог бий болгох, түүний тогтвортой үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхэд шаардлагатай макроэдийн засгийн таатай нөхцлийг бүрдүүлэх, санхүүгийн болон хөдөлмөрийн, барааны зах зээлын уялдааг сайжруулах, материал, техникийн баазыг байгуулах, үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцааг бий болгох,

зохиогчийн эрхийг хамгаалах тогтолцоог байгуулах, эхний шатанд компаниудын инновацийн үйл ажиллагааг урамшуулах санхүүгийн (хувийн хэвшлийн венчурын хөрөнгийг бий болгох) тогтолцоог бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрийн инновацийн үйл ажиллагааг дэмжих сангуудыг бий болгох, инновацийн гадаад зах зээлтэй үндэсний үйлдвэрлэгчдийг холбоход ихээхэн ач холбогдол өгөх ёстой байдаг. Зураг 2-оос харна уу.



Зураг 2. Монгол улсын инновацийн тогтолцооны загвар

Монгол Улсын эдийн засаг нь жижиг, зах зээлийн багтаамж багатай, гадаад эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөнд өртөмтгий, өрсөлдөх чадвар сул, олон улсын хөдөлмөрийн хуваарьт хамрагдах оролцоо, гүйцэтгэх үүрэг багатай боловч, динамик шинжтэй, манервлах чадвар сайн, инерци багатай тул богино хугацаанд хөл дээрээ босч хөгжих боломж илүү гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, жижиг эдийн засгийг жижиг бизнестэй зүйрлүүлж болох юм. Эндээс жижиг эдийн засагт жижиг дунд бизнесийн чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн санааг дэвшүүлж байгаа юм.


Манай орны үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх суурь нөхцөл бүрэлдээгүй боловч, хөгжлийн хоцрогдлыг богино хугацаанд арилгах гол хүчин зүйл нь шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжил бөгөөд түүнийг төрийн зүгээс хөрөнгө санхүүгээр

эрчимтэй цаг алдалгүй дэмжих шаардлага гарч байна. Инновацийн үйл ажиллагааны мөн чанар нь хүний оюуны нөөц, чадамж, дадлага туршлагыг бүрэн ашигласанаар эдийн засгийн өсөлтийг хамгийн их үр ашигтай болгоход оршдог гэж дэлхийн эрдэмтэд үзэж байна.

Дэлхийн шинээр аж үйлдвэржсэн Өмнөд Солонго, Тайланд, Сингапур, Турк, Чили, Португал зэрэг орнуудын инновацийн бодлого нь ихэвчлэн шинэ технологийг бий болгоход чиглэгдэхээс илүү өндөр технологийг нутагшуулах, түгээх, боловсруулах салбарт нэвтрүүлэх, хөнгөн үйлдвэрийн боловсон хүчнийг бэлтгэх, шилдэг менежментэд сургахад чиглэгдэж байна. Эдгээр орнуудын инновацийн хөгжлийн high-tech-ээс high-hume рүү чиглэсэн бодлогын энэхүү загвар нь тэднийг богино хугацаанд эдийн засгийн өндөр өсөлтөд хүрч болдогыг харуулж байна.

Эдгээр орнуудтай адил Монгол Улсын төрийн зүгээс үндэсний инновацийн тогтолцоог бий болгоход шаардлагатай элементүүд, дэд бүтцийг юуны түрүүнд бий болгох нь чухал юм. Энэ нь шинэ технологийг бий болгоход биш, харин нутагшуулахад анхаарч, “high-hume” хөгжүүлэх замаар байгаль орчинд хор хөнөөлгүй шилдэг техник технологи ашиглан байгалийн баялаг болон хөдөө аж ахуйн түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлож чадвал Монгол Улс 5-6 жилийн дотор аж үйлдвэржсэн улс болох бүрэн боломжтой гэж үзэж байна.

Аливаа улсын үндэсний инновацийн тогтолцооны суурь нь кластерын загвараар компаниудын хоорондын босоо, хэвтээ хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд оршиж байна. Зураг 3-аас харна уу.



Зураг 3. ХАА-ын кластер

Кластер гэж компаниудын бөөгнөрөл бөгөөд тэдгээр нь нэгж бүтээгдхүүнийг үйлдвэрлэхэд гарах өртөг зардлыг буурлахын тулд үйлдвэрлэл, техник, технологийн, материал, түүхий эдийн хангамж, нийлүүлэлт, борлуулалт, хадгалалт, мэдээлэл, харилцаа, маркетинг, дэд бүтэц, удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн сүлжээгээр хоорондоо холбогдож, тодорхой төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дээр дагнах, төрөлжөх, хамтрах, эрсдэлийг тараах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Инновацийн кластеруудын мөн чанар нь тухайн орон нутгийн (байгалийн баялаг, ажиллах хүч, санхүү, дэд, бүтэц, техник, технологи гэх мэт) давуу тал дээр тулгаарлан хамгийн бага зардлаар бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ороход оршиж байна. Ингэснээр хөдөө орон нутаг санхүү, эдийн засгийн бие даасан, тэнцвэртэй байдал хангагдаж

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн сүүлийн хэдэн жилийн үзүүлэлтүүд “Голланд өвчин”-д бүрэн нэрвэгдсэн гэдгийг гэрчилж байна. Иймд уул уурхай дээр тулгуурласан

хөгжлийн одоогийн загвараар цаашид явах боломжгүй болох нь харагдаж байна. Энэхүү загварыг өөрчилж Монгол Улс үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бий болгоход санхүүгийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг яаралтай авч, Голланд өвчнөөс урьдчилан сэргийлж байгаа, инновацийн кластерыг байгуулах замаар бүс нутгаа хөгжүүлж байгаа олон улсын туршлагаас суралцаж байгалийн баялагаа үр өгөөжтэй ашиглах, монгол хүнээ хөгжүүлэх, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах цаг нь болсон гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ:

1. Krugman, Paul (1987). “The Narrow Moving Band, the Dutch Disease, and the Competitive Consequences of Mrs. Thatcher”. Journal of Development Economics. 27 (1-2): 50. [doi:10.1016/0304-3878\(87\)90005-8](https://doi.org/10.1016/0304-3878(87)90005-8).
2. Van Wijnbergen, Sweder (1984). “The ‘Dutch Disease’: A Disease After All?”. The Economic Journal. 94 (373): 41. [doi:10.2307/2232214](https://doi.org/10.2307/2232214).
3. Geography and Economic Growth. John Luke Gallup, Jeffrey Sachs, Andrew M. Warner /April 1998/ . John Luke Gallup, Jeffrey Sachs, Andrew M. Warner /April 1998/
4. We Can Now Cure Dutch Disease, By Joseph Stiglitz, Guardian. August 18, 2004
5. Jeffrey D. Sachs, Andrew M. Warner “Natural resource abundance and economic growth”, Working paper 5398, National bureau of economic research Cambridge December 1995
6. Монгол Улсын Үндэсний Аудитын газраас “Хүний хөгжил сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн” хийсэн аудитын тайлан. Улаанбаатар, 2014. <http://www.audit.gov.mn/files/report/compliance/hugjil-san.pdf>
7. Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл, 2012-2016 он.
8. Монгол банкны статисткийн эмхэтгэл, 2012-2016 он.
9. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл 2014 он